

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 2 ДУГААР  
УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төлөвлөлт уялдаа		Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт			Гүйцэтгэлийн төлөвлөгөө	
ТАБ-ын төлөвлөгөөний дугаар	ТАГ-ын төлөвлөгөөний дугаар		Суурь төвшин (Үйл ажиллагаа болон бодлого, арга хэмжээний хэрэгжиж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утга)	Шалгуур үзүүлэлт (үйл ажиллагаа болон бодлого, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлт)	Хүрэх төвшин (Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утга)	Хэрэгжилт	Хувь
<b>ХОЁР. ТӨРИЙН АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>							
<b>Зорилт 2.1 Төрийн аудитын үйл ажиллагааг төлөвлөгөөт цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх стратеги зорилтын хүрээнд</b>							
	2.2	Өөрийн болон хараат бус аудитын компанийн аудитуудын 2022 онд хийх санхүүгийн тайлангийн аудитын хуваарийг батлуулж, хяналт тавьж ажиллах	Аудиторуудын 2021 онд хийх аудитын хуваарийг дарга бөгөөд тэргүүлэх аудитораар батлуулж, хяналт тавьж ажилласан.	Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалтыг үндэслэн, хуваарь батлагдсан байх	Аудиторуудын 2022 онд хийх аудитын хуваарийг батлуулж, хяналт тавьж ажилласан байна.	Өөрийн болон хараат бус аудитын компанийн аудиторуудын 2022 онд хийх санхүүгийн тайлангийн аудитын хуваарийг гаргаж, аудитад хамрагдах байгууллагын жагсаалт /А20101/, аудит хийх хэлбэрийг /А30101/ маягаар тус тус гаргаж Аудитын нэгдүгээр газарт 6-р сарын 08-ны өдөр хүргүүлсэн. Аудит хийх хуваарь МУЕА-аар батлагдаж ирэхээр аудитор бүрийн хийх хуваарийг Дарга, тэргүүлэх аудитораар батлуулж, СТАУС программд оруулна.	
2.4	2.3	Аймгийн Засаг даргаас тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлсэн 2022 оны жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт, санал боловсруулж, аймгийн	Орон нутгийн 2021 оны төсвийн төсөлд татварын 7 нэр төрлийн орлогыг 932.0 сая төгрөгөөр, төрийн болон орон нутгийн өмчийн орлогыг 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр санал оруулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 78 дугаар тогтоолоор батлуулсан.	Орон нутгийн төсвийн 2022 оны төсөлд "Төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх" талаар санал боловсруулан, батлуулах	Орон нутгийн төсвийн 2022 оны төсөлд "Төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, зардал бууруулах, орлого нэмэгдүүлэх саналыг боловсруулан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн	Аудиторууд хийгдэж буй аудитаас "Төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх" талаар санал боловсруулж байна.	

		Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх			хуралд танилцуулж, батлуулна.	
2.5	2.4	Байгууллагаас 2021 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн санхүүгийн аудитыг цаг хугацаанд нь чанартай, үр өгөөжтэй хийж гүйцэтгэх	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалаар баталсан манай байгууллагаас 2020 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн санхүүгийн 198 аудитыг төлөвлөгөөт хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартууд; Санхүүгийн аудитын дүрэм, журам;	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/64 дугаар тушаалаар баталсан байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэрийн хүрээнд санхүүгийн 199 аудитыг баталсан хугацаанд стандартын дагуу чанартай гүйцэтгэж, нийгэмд үзүүлэх үр нөлөө, үр өгөөжийг дээшлүүлнэ.	199 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг баталсан хугацаанд стандартын дагуу чанартай гүйцэтгэж, дүгнэлт гарган, 102 байгууллагын санхүүгийн тайланд түүвэр аудитыг хийлээ. Тус аудитаар нийт 621 төрлийн 9144.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 228 төрлийн 5580.9 сая төгрөгийн алдааг залруулж, 143.9 сая төгрөгийн зөрчилд 48 акт, 1759.6 сая төгрөгийн зөрчилд 33 албан шаардлага тогтоож, 1644.1 сая төгрөгийн зөрчилд 302 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ. Аудитаар нийт 7011.8 сая төгрөгийн үр өгөөжийг бүртгэлээ. Хэрэгжилтийг авч үзэхэд 37 төлбөрийн актын 102.6 сая төгрөг, 29 албан шаардлагын 693.0 сая төгрөг, 594.2 сая төгрөгийн 174 зөвлөмжийн биелэлт хангагдсан байна.
2.5	2.6	Төсвийн шууд захирагчдын 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулах СТА	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/64 дугаар тушаалаар санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, хэлбэрийг, байгууллагын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2020 оны А/114 дүгээр тушаалаар санхүүгийн тайлангийн аудит хийх хуваарийг батлуулсан.	ТТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд АОУС, АДБОУС, ТАБ-ын аудит хийх журам, зааврын дагуу аудитыг чанартай хийж, гүйцэтгэсэн байх	ТТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд АОУС, АДБОУС, ТАБ-ын аудит хийх журам, зааврын дагуу аудитыг чанартай хийж, гүйцэтгэн дүгнэлт өгсөн байх	166 төсвийн шууд захирагчдын 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гарган, 98 байгууллагын санхүүгийн тайланд түүвэр аудитыг хийлээ. Аудитаар нийт 577 төрлийн 5457.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 203 төрлийн 5509.8 сая төгрөгийн алдааг залруулж, 140.9 сая төгрөгийн зөрчилд 48 акт тогтоож, 1423.0 сая төгрөгийн зөрчилд 41 албан шаардлага хүргүүлж, 1383.3 сая төгрөгийн зөрчилд 277 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ. Ажлын хариуцлага алдсан 8 албан тушаалтанд хариуцлагын арга хэмжээ авахуулахаар холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлээ. Хэрэгжилтийг хангах хугацаа болсон акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

2.5	2.7	Засгийн газрын тусгай сангийн 2020 төсвийн оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулах СТА	Нийгмийн халамжийн сан, Нийгмийн даатгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт өгсөн.	МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/64 дугаар тушаал, байгууллагын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2020 оны А/114 дугаар тушаалаар батлагдсан төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт өгөх	Төсвийн тухай хуулийн 8-р зүйлийн 8.9.1 дэх заалтад заасан хугацаанд тухайн сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитыг чанартай гүйцэтгэн, дүгнэлт өгнө.	Нийгмийн халамжийн сан, Нийгмийн даатгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт өгсөн. Аудитаар нийт 3 төрлийн 13.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 2 төрлийн 13.0 сая төгрөгийн алдааг залруулж, 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаа.	
2.5	2.8	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулах СТА	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/64 дугаар тушаалаар санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, хэлбэрийг, байгууллагын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2020 оны А/114 дугаар тушаалаар санхүүгийн тайлангийн аудит хийх хуваарийг батлуулсан.	Шинэчлэгдэн батлагдсан санхүүгийн тайлангийн аудитын журам, заавар	Төсвийн тухай хуулийн 8-р зүйлийн 8.9.8 дахь заалтын хугацаанд санхүүгийн тайлангийн аудитыг чанартай хийж гүйцэтгэн дүгнэлт өгнө.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 8 хуулийн этгээдийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт өгсөн. Тус аудитаар нийт 24 төрлийн 136.1 сая төгрөгийн алдаа зарчил илэрсэнээс 10 төрлийн 112.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 15.5 сая төгрөгийн алдаанд 1 албан шаардлага, 8.2 сая төгрөгийн зөрчилд 13 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хугацаа болоогүй болно	
2.5	2.9	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулах аудит			Төсвийн тухай хуулийн 8-р зүйлийн 8.9.2 дахь заалтад заасан хугацаанд санхүүгийн тайлангийн аудитыг чанартай хийж гүйцэтгэн, дүгнэлт өгнө.	26 төсвийн төвлөрүүлэн захирагчдын 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргалаа. Аудитаар 17 төрлийн 31.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, аудитын явцад 7 төрлийн 31.9 сая төгрөгийн алдааг залруулж, 9.0 сая төгрөгийн зөрчилд 8 заалт бүхий зөвлөмж хүргүүлж, ажлын хариуцлага алдсан 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Хэрэгжилтийг хангуулах хугацаа болоогүй болно.	

2.5	2.11	Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж баталгаажуулах санхүүгийн тайлангийн аудит	Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/64 дугаар тушаалаар санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, хэлбэрийг, байгууллагын дарга бөгөөд тэргүүлэх аудиторовн 2020 оны А/114 дугаар тушаалаар санхүүгийн тайлангийн аудит хийх хуваарийг батлуулсан.	ТТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаварт хугацаанд АОУС, АДБОУС, ТАБ-ын аудит хийх журам, зааврын дагуу аудитыг чанартай хийж, гүйцэтгэсэн байх	Төсвийн тухай хуулийн 8-р зүйлийн 8.9.4 дахь заалтад заасан хугацаанд санхүүгийн тайлангийн аудитыг чанартай хийж гүйцэтгэн, дүгнэлт өгнө.	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж баталгаажуулах санхүүгийн тайлангийн аудитыг хуулийн хугацаанд хийж холбогдох газруудад хүргүүлсэн. Тус аудитаар 8 төрлийн 632.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, аудитын явцад 4 төрлийн 73.6 сая төгрөгийн алдааг залруулж, 321.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 237.5 сая төгрөгийн зөрчилд 3 заалт зөлөмж хүргүүллээ. Хэрэгжилтийг хангуулах хугацаа болоогүй болно.	
1.10	2.12	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлд аудит хийх	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль 2020 онд шинэчлэн батлагдсан, арга зүй байхгүй	Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн дагуу сонгуульд нэр дэвшигчдийн зардлын дээд хэмжээг тогтоох боломжтой болсон байх	Нам, эвсэл, нэр дэвшигчийн ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын дээд хязгаар тогтоох аргачлал батлагдсан байна	Аудитын төлөвлөлтийн өмнөх шатны ажил хийгдэж байна.	
	2.13	2020 оны Санхүүгийн тайлангийн аудитын баталгаажуулалтын нэгдсэн дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хуралд танилцуулах	Санхүүгийн тайлангийн аудитын баталгаажуулалтын нэгдсэн дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хуралд жил бүр танилцуулдаг.	Санхүүгийн тайлангийн аудитын баталгаажуулалтын нэгдсэн дүнг гаргаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хуралд танилцуулах	Санхүүгийн тайлангийн аудитын баталгаажуулалтын нэгдсэн дүнг тайлагнаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор баталгаажуулна.	Тухайн цаг үед орон нутагт Ковид-19 цар тахлын хатуу хөл хориотой байсан учир 2020 оны Санхүүгийн тайлангийн аудитын баталгаажуулалтын нэгдсэн дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн даргад танилцуулж, тайлан судалгааг хүргүүлсэн болно	
2.11	2.14	Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг /ЗАА-2021/06-12-ШТА-ГА/	“Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т 2020 оны 01-р сараас 06 сар хүртэлх хугацаанд аудит хийж тайлан, судалгааг холбогдох газруудад хүргүүлсэн.	Аудитыг АДБОУС, ТАБ-аас аудит хийх журам, зааврын дагуу чанартай хийж, гүйцэтгэсэн байх	АДБОУС, MNS 6817 стандартад нийцсэн чанартай тайлан бэлтгэж, хянуулан баталгаажуулж, батлагдсан хугацаанд хүргүүлсэн байна	Аудитыг заасан хугацаанд бүрэн гүйцэтгэж, аудитын тайлан судалгааг холбогдох газруудад хүргүүлсэн. Аудитаар нийт 6980.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 229.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 6750.9 сая төгрөгийн 11 төрлийн зөрчилд 12 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.	

	2.15	Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжин хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн, үр ашиг /ЗАА-2021/15-12-ШТА-ГА/	Санхүүгийн тайлан баталгаажуулалтаар илэрсэн зөрчил, өгсөн дүгнэлт, дотоод хяналтын тайлан, санхүүгийн дотоод хяналтын тайлан дүгнэлтүүд, хөтөлбөрүүдийн хэрэгжилт үр дүн, салбар яамны хөндлөнгийн хяналтыг үндэслэл болгоно.	Аудитыг АДБОУС, ТАБ-аас аудит хийх журам, зааврын дагуу чанартай хийж, гүйцэтгэсэн байх	Аудитыг төлөвлөгөөт хугацаанд чанартай, үр өгөөжтэй гүйцэтгэж, тайлан судалгаа материалыг холбогдох газруудад хүргүүлнэ.	Аудитыг заасан хугацаанд бүрэн гүйцэтгэж, аудитын тайлан судалгааг холбогдох газруудад хүргүүлээд байна. Аудитаар илэрсэн алдаа зөрчилд үндэслэн 22.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тус тус тогтоож, 42.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 7 заалт зөвлөмж хүргүүлж, 7.6 сая төгрөгийн зөрчлийн асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлнэ.	
	2.16	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаар олгосон зээлийн зарцуулалт, үр дүн /ЗАА-2021/15-12-ШТА-ГА/	2017-2019 онуудад хийсэн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн эргэн төлөлтөд хийсэн дүгнэлт, судалгаа, тайлбар болон тус зээлийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүгнэлтэд үндэслэнэ.	Аудитыг АДБОУС, ТАБ-аас аудит хийх журам, зааврын дагуу чанартай хийж, гүйцэтгэсэн байх	АДБОУС, MNS 6817 стандартад нийцсэн чанартай тайлан бэлтгэж, хянуулан баталгаажуулж, батлагдсан хугацаанд хүргүүлсэн байна	Аудитыг заасан хугацаанд бүрэн гүйцэтгэж, аудитын тайлан судалгааг холбогдох газруудад хүргүүлээд байна. Аудитаар илэрсэн алдаа зөрчилд үндэслэн 8 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.	
2.15	2.17	Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн /ЗАА-2021/14-12-ШТА-ГА/	Өмнөх онуудад уг сэдвээр аудит гүйцэтгээгүй	Аудитыг АДБОУС, ТАБ-аас аудит хийх журам, зааврын дагуу чанартай хийж, гүйцэтгэсэн байх	АДБОУС, MNS 6817 стандартад нийцсэн чанартай тайлан бэлтгэж, хянуулан баталгаажуулж, батлагдсан хугацаанд хүргүүлсэн байна	Нэгдсэн удирдамжаар хийгдэх "Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн хөрөнгийн үр дүн" сэдэвт аудитын нутгийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр дүнд судалгаа хийж аудитын нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээг хийж, аудитын хамрах хүрээ, аудитаар авч үзэх асуудалд санал бэлтгэн аудитын гуравдугаар газарт хүргүүлсэн. Одоогоор гуравдугаар газраас нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөр ирээгүй байна.	

2.18	2.19	Төрийн байгууллагын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт /ЗАА-2021/15-12-ШТА-ГА/				Нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрөөр хийгдэх "Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт" гүйцэтгэлийн аудитын төлөвлөлтийн үе шатны ажилд орон нутгийн хэмжээнд төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтийн байдалд урьдчилсан судалгаа хийж аудитын нөхцөл байдлыг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээг хийж, аудитын хамрах хүрээ, аудитаар авч үзэх асуудалд санал боловсруулж аудитын гуравдугаар газарт хүргүүлсэн. Одоогоор гуравдугаар газраас нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөр ирээгүй байна.	
2.30	2.21	2021 онд гүйцэтгэх сэдвийн хүрээнд гүйцэтгэл, нийцлийн аудитыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх	МУЕА-ын 2020 оны А/53 дугаар тушаалаар гүйцэтгэл, нийцлийн аудитыг хийж гүйцэтгэсэн.	Аудитыг АДБОУС, ТАБ-аас аудит хийх журам, зааврын дагуу чанартай хийж, гүйцэтгэсэн байх	АДБОУС, MNS 6817 стандартад нийцсэн чанартай тайлан бэлтгэж, хянуулан баталгаажуулж, батлагдсан хугацаанд хүргүүлсэн байна	Тайлант хугацаанд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитыг төлөвлөсөн цаг хугацаанд нь гүйцэтгэж аудитын тайлан, судалгааг холбогдох газруудад хүргүүлж байна	
2.31	2.22	ТАБ-аас 2021 онд нэмэлтээр хийх, өмнөх оноос шилжиж ирсэн болон төлөвлөгөөт бус аудитыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх	Өмнөх оноос шилжиж ирсэн аудитын хувьд урьдчилсан судалгаа, төлөвлөлт, гүйцэтгэлийн үе шатны ажлууд хийгдсэн	МУЕА-ын тушаалаар баталсан аудитын сэдвийн хүрээнд Аудитыг АОУС, АДБОУС, ТАБ-аас аудит хийх журам, зааврын, дагуу чанартай хийж, гүйцэтгэсэн байх	АДБОУС, MNS 6817 стандартад нийцсэн чанартай тайлан бэлтгэж, хянуулан баталгаажуулж, батлагдсан хугацаанд хүргүүлсэн байна	Тайлант хугацаанд нэмэлтээр хийх, өмнөх оноос шилжиж ирсэн болон төлөвлөгөөт бус аудит хийгдээгүй болно	
<b>Зорилт 2.2 Аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг дээшлүүлж, үйл ажиллагааны нэгдсэн тайлан гаргах стратеги зорилтын хүрээнд</b>							
2.33	2.22	Аудитын мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг сайжруулах, холбогдох арга хэмжээ хэрэгжүүлэх /зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт хийх/	Өмнөх жилүүдэд хийсэн аудитын тайлан, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгасан	Аудитыг MNS 6817 стандарт, АОУС, АДБОУС, ТАБ-аас аудит хийх журам, зааврын, дагуу чанартай хийж, гүйцэтгэсэн байх	Зөвлөмж, акт, албан шаардлага биелэлтийн хувь өссөн байна.	Аудитын мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг сайжруулах зорилгоор зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг 14 хоног тутамд гаргаж, хамт олны шуурхайгаар хэлэлцэж тогтоосон хугацаанд барагдуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Акт, албан шаардлагын хэрэгжих хугацаа дууссан байгууллагуудад төлбөр, албан шаардлагыг барагдуулахгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ноогдуулахыг	

						анхааруулж албан тоотыг хүргүүлэн ажиллаж байна.	
<b>Зорилт 2.3 Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайланд хийх аудитад хөндлөнгийн хараат бус аудитын хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхийг сайжруулах стратеги зорилтын хүрээнд</b>							
2.35	2.23	Аудитын хуулийн этгээдийн сонгон шалгаруулах ажлын хэсэгт ажиллах, санал өгөх, гэрээ байгуулах	2020 оны санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг өмнөх гэрээний сунгалтыг хийж, гэрээ байгуулсан	"Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах заавар, аргачлал"-ын дагуу үнэлж, дүгнэсэн байх	Сонгогдсон хуулийн этгээдүүдтэй нэг бүрчлэн гэрээ байгуулсан байна	2020 оны санхүүгийн тайлангийн аудитад өмнөх 2 онд гэрээгээр ажилласан хараат бус хуудийн этгээдтэй аудит хийх гэрээг сунгаж ажиллуусан. 2021-2022 оны санхүүгийн тайлангийн аудитад сонгон шалгаруулах хуулийн этгээдийн ажлын багцыг үүсгэн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, баталсан байгаа. Аудит хийх байгууллагын жагсаалт, хэлбэр МУЕА-аар батлагдан ирэхээр сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд тавих болно.	
2.36	2.24	Аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад чанарын хяналт хийх	2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хараат бус аудитын компаниудын хийсэн аудитад чанарын хяналт хийсэн	ТТХ-д заасан цаглаварт хугацааг мөрдсөн эсэх, "Аудитын чанарын хяналтын журам", "ТАБ-аас аудит хийх журам", зааврыг хэрэгжүүлсэн эсэх	Аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн аудитад чанарын хяналт хэрэгжүүлэн ТТХ-ийн 8 дугаар зүйл заасан цаглаварт хугацаанд аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүлсэн байна	2020 оны санхүүгийн тайлангийн аудитад 2 ХАК-тай гэрээ байгуулан 99 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх ажлыг гүйцэтгүүлсэн ба гүйцэтгэсэн ажилд СТА-ын ахлах аудитор, аудитын менежер, Тэргүүлэх аудитор нар үе шатны чанарын хяналтыг хийж гүйцэтгэсэн.	
2.37	2.25	Аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн санхүүгийн аудитын үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлж тайлагнах	Санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн хувийн аудитын компаниудын хийсэн аудит үйл ажиллагааг үнэлж тайлагнасан	ТТХ-д заасан цаглаварт хугацааг мөрдсөн эсэх, "Аудитын чанарын хяналтын журам", "ТАБ-аас аудит хийх журам", зааврыг хэрэгжүүлсэн байх	Аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн аудитын үе шат бүрт үнэлгээ өгч, үнэлгээний нэгтгэсэн дүнг гаргасан байна	"Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам"-ын дагуу хавсралтаар аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн аудитын үе шат бүрт СТА-ын ахлах аудитор, аудитын менежер, Тэргүүлэх аудитор нар үнэлгээ өгч, үнэлгээний нэгтгэсэн дүнг гаргаж, ХАК-дад хүргүүлсэн болно. Гэрээгээр ажилласан "Сүлд аудит" ХХК, "Мэдээлэл аудит" ХХК-ний Завхан аймаг дахь салбар тус бүр хангалттай үнэлгээ авлаа.	
<b>ГУРАВ.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА</b>							

**Зорилт 3.1 Харилцагч талуудтай байнгын, үр дүнтэй харилцах тогтолцоог бүрдүүлэх стратеги зорилтын хүрээнд**

3.1	Байгууллагын цахим хуудаст үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр байршуулж, олон нийтэд түгээж, мэдээлэх	Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	Төрийн аудитын газраас гаргасан шийдвэр, аудитын тайланг байгууллагын цахим хуудаст цаг тухайд нь байршуулсан байх, Баталгаажсан аудитын тайлан, бусад холбоотой материалуудыг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргэх	Аудитын үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүд холбогдох хүмүүст хүрсэн байна.	Байгууллагаас гаргасан шийдвэр, аудитын тайланг байгууллагын цахим хуудаст цаг тухайд нь байршуулж байгаа. Баталгаажсан аудитын тайлан, бусад холбоотой материалуудыг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргэн ажиллаж байна.
3.2	Санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлж, байгууллагын үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар иргэдийг бодит мэдээллээр хангах	Zavkhan.audit.mn сайтад санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын тайланг мэдээлж ирсэн.	Zavkhan.audit.mn сайтад санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын тайланг ил тод мэдээлэх	Аудитын үр дүнгийн талаарх тайлан, дүгнэлт, зөвлөмж түүний хэрэгжилтийн үр дүнг нээлттэй болгох тогтолцоо дээшилнэ.	Тайлант хугацаанд 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дүгнэлт өгсөн 199 байгууллагын дүгнэлт тайлан, зөвлөмж, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2020 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийгдсэн ГА-ын тайлан, дүгнэлт зөвлөмжийг байгууллагын цахим сайтад байршуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлж, олон нийтэд мэдээлсэн.
3.3	Төрийн аудитын байгууллагын эрх ашгийг хамгаалах зорилгоор удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу шүүх, прокурор, бусад эрх бүхий байгууллагатай харилцах, байгууллагад учирсан аливаа хохирлыг барагдуулах талаар хууль, хяналтын байгууллагад хүсэлт, нэхэмжлэл гаргах, шүүхэд төлөөлж, нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	Шүүх, Прокурор, бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажилладаг.	Чиг үүргийн дагуу төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүх, прокурор, эрх бүхий бусад байгууллагатай харилцах, Шүүхэд төлөөлж, нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох, Байгууллагад учирсан аливаа хохирлыг барагдуулах талаар хууль, хяналтын байгууллагад хүсэлт, нэхэмжлэл	Төрийн аудитын байгууллага, Монгол Улсын Ерөнхий аудитор, ажилтан албан хаагчдыг чиг, үүргийн дагуу төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулж бүх шатны шүүх хуралд төлөөлөн оролцох, хууль хяналтын байгууллагуудтай харилцах, байгууллагад учирсан аливаа хохирлыг барагдуулах талаар хууль, хяналтын байгууллагад	Дөрвөлжин сумын төсөвт байгууллагуудын 2020 оны жилийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар тус байгууллагуудад дулаан ханган нийлүүлэгч "Ган доной"ХХК нь барилга эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл болон дулааны үнэ тариф тогтоолгоогүй байгаа нь Барилгын тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байж болзошгүй тул шалган шийдвэрлүүлэхээр аймгийн Прокурорын газарт хүргүүлсэн. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн иргэн хуулийн этгээдэд олгосон төслийн зээлийн хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй, төр хохирч байгаа үйлдэлд итгэмжлэлээр оролцож хохирлыг холбогдох этгээдээс төлүүлэхийг аймгийн Прокурорын газар болон Тосонцэнгэл сум дахь сум дундын прокурорын газруудад холбогдох сумдын асуудлыг тус тус шилжүүлсэн.



				гаргах, Үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах	хүсэлт, нэхэмжлэл гаргана.		
3.4	Хуулийн байгууллагад шилжүүлсэн мэдээллийг бүртгэн, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн мэдээллийн бүртгэлийг хөтөлж байна.	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлыг бүртгэн, биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах, бүртгэл судалгааг Үндэсний аудитын газарт хүргүүлэх	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлын биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулсан байна.	Хуулийн байгууллагад шилжүүлсэн мэдээллийг бүртгэн, биелэлтийг хангуулах ажлыг Тэргүүлэх аудитор, аудитын менежер нар зохион байгуулан хэрэгжүүлж байна.  Тайлант онд хууль хяналтын байгууллагад 992.9 сая төгрөгийн 269 асуудлыг шилжүүлэн хянагдаж байна. Үүнээс 985.0 сая төгрөгийн 268 асуудал нь сумдын сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой асуудал болно.		
3.5	Байгууллагад ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хяналт тавих	Хууль тогтоомжийн дагуу хүлээн авч, шийдвэрлэж байна.	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн байх	Өргөдөл, санал, гомдлыг хуульд заасан хугацаанд, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж мэдээ тайланг гаргасан байна.	Тайлант хугацаанд байгууллага, иргэдээс нийт 15 өргөдөл, саналыг хүлээн авч хуулийн хугацаанд хариу шийдвэрийг хүргүүлсэн болно.		
3.6	Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж болон эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар санал боловсруулж, Үндэсний аудитын газарт хүргүүлэх	Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж болон эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар санал боловсруулж хүргүүлдэг.	Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудыг шинэчилж, боловсронгуй болгоход санал боловсруулж хүргүүлэх	Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж болон эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар санал боловсруулж хүргүүлдэг.	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитын явцад 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Улиастай сумын Богдын гол багийн Цэнгэлдэх хотхоныг цэвэр, бохир, дулааны шугам сүлжээ ажлыг тендер сонгон шалгаруулалтгүй шууд гэрээ байгуулсан, экспертийн дүгнэлтээр зураг төсөв зөрчилтэй байхад гүйцэтгэсэн зэрэг нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тул Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэж өгөхийг 2021.03.31-ний 490 тоотор Монгол Улсын Ерөнхий аудиторт уламжилсан бөгөөд Улсын ерөнхий прокурорын газарт шилжүүлээд байна.		

3.7	Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал, сар улирлаар хуваарилан, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төлөвлөгдсөн арга хэмжээг санхүүжүүлэх, санхүүгийн тайланг гарган санхүүгийн аудит хийлгэх	Өмнөх оны батлагдсан төсвийг хуваарийн дагуу зарцуулж тайлагнасан. Өр авлага үүсээгүй.	Батлагдсан төсвийн хүрээнд төсвийн хөрөнгөөр бараа материал ажил үйлчилгээг худалдан авах, зардлыг санхүүжүүлэх	Төсвийн ил тод байдлыг хангаж, төлөвлөлтийг оновчтой хийж, сахилга хариуцлагыг дээшлүүлснээр байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал, сар улирлаар хуваарилан батлуулж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулан төлөвлөгдсөн арга хэмжээг санхүүжүүлэн ажиллаж байна  2021 онд 477.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас эхний хагас жилд 240.8 сая төгрөгийн орлого санхүүжилттэй үйл ажиллагаа явуулж, батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомж, заавар, журам, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж ажиллаа. Батлагдсан төсвөөс бичиг хэргийн зардал 641.6 мянган төгрөг, шуудан, холбоо, интернэтийн зардал 128.0 мянган төгрөг дутуу санхүүжигдэж, нийт 769.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд тайлагнаж, “Мишээл-Од Аудит” ХХК-аар баталгаажуулан, “Зөрчилгүй” санал дүгнэлт авч, санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар өгөгдсөн 4 заалт бүхий зөвлөмжийг хэрэгжүүлэн, хариуг хугацаанд нь албан тоот, нотлох баримтын хамт хүргүүлээ.	
3.8	Нийгмийн даатгал, татварын байгууллагуудтай тооцоог цаг хугацаанд нь бүрэн хийх, өглөг авлагагүй ажиллах	Өмнөх онд нийгмийн даатгал, татварын байгууллагуудтай тооцоог цаг хугацаанд нь бүрэн хийж, өглөг авлагагүй ажилласан.	Нийгмийн даатгалын шимтгэл, татвараа үнэн зөв тооцоолж, цаг хугацаанд нь холбогдох газруудад тайлагнах	Нийгмийн даатгал, татварын байгууллагуудтай тооцоог цаг хугацаанд нь бүрэн хийж өглөг, авлагагүй ажилласан байна.	Нийгмийн даатгалын тайланг сар бүр, татварын тайланг улирал бүр онлайн программаар гарган, холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж, баталгаажуулан, өглөг авлагагүй ажиллаа.	
3.9	Байгууллагын төсвийг төлөвлөх, төсвийн хязгаарын санал боловсруулах, төсвийн төслийн санал бэлтгэж, Үндэсний аудитын газрын	Байгууллагын 2021 оны төсвийн хязгаарын санал, төсвийн төслийн санал бэлтгэж, Үндэсний аудитын газрын Ажлын албанд хүргүүлсэн.	Төсвийн шууд захирагчийн 2022 оны төсвийн хязгаарын санал, төсвийн төслийн саналыг бэлтгэж, Үндэсний аудитын	Байгууллагын 2022 оны төсвийн хязгаарын санал, төсвийн төслийн санал бэлтгэж, Үндэсний аудитын газрын холбогдох	Төсвийн шууд захирагчийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын болон төсвийн төслийн саналыг хугацаанд нь боловсруулж, Захиргаа удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлээ.	

		холбогдох газарт хүргүүлэх		газрын холбогдох газарт хүргүүлэх	газарт хүргүүлэн, батлуулсан байна.	
	3.10	Дорнод аймгийн Төрийн аудитын газрын ажилтай танилцаж, туршлага судлах	Өмнөх онд Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай аймгуудын төрийн аудитын газрын ажилтай танилцаж, туршлага судалсан.	Ажлын туршлага солилцох	Туршлага солилцсоноор албан хаагчдын ажлын үр дүн сайжирна.	Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хийгдээгүй байна.
	3.12	Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, тавилга, тоног төхөөрөмжийг шинэчлэх	Өмнөх онд аймгийн ЗДТГ-т санал тавьж ажлын өрөөнүүдэд засвар хийлгэж тохижуулсан.	Албан хаагчдын ая тухтай ажиллах орчин бүрдүүлэх	Албан хаагчдын ажиллах орчин, нөхцөл сайжирсан байна.	Хэрэгцээтэй тавилга, тоног төхөөрөмжийг шинэчлэх саналыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн байгаа.

**ДӨРӨВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, СУРГАЛТ**

**Зорилт 4.1 Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын ёс зүйг дээшлүүлэх, шударга байдлын тогтолцоог бий болгож төлөвшүүлэх стратеги зорилтын хүрээнд**

4.2	4.1	Байгууллагын албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэгт холбогдохоос сэргийлэх, чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан хууль эрх зүйн актыг сурталчлах, мэдээлэл өгөх	Ёс зүйн журам мөрдөж байгаа	Байгууллагын ажилтнууд ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчилд орохгүй байх, гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулсан эсэх	Хууль тогтоомжийн мэдээллээр хангаж, сургалт сурталчилгаа явуулсан байна.	Хууль эрх зүйн актын шинэчлэлийг тухай бүрт нь албан хаагчдад танилцуулж ажилладаг.
4.3	4.2	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээг бүрэн зохион байгуулж тайлагнасан.	Хууль тогтоомжид заасан шалгуур үзүүлэлтийг хангасан байх, тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж өгсөн байх	ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд гаргаж, тайланг Авлигатай тэмцэх газарт тайлагнасан байна. Аудитын үйл ажиллагаа сонирхлын зөрчлөөс ангид байна.	Албан хаагчдын 2020 оны ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд гаргаж, тайланг Авлигатай тэмцэх газарт тайлагнасан. Аудитын үйл ажиллагааг сонирхлын зөрчлөөс ангид хэрэгжүүлж байна.

**Зорилт 4.2 Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх стратеги зорилтын хүрээнд**

	4.3	Байгууллагын 2021 онд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлж ажиллах	Өмнөх онд байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлж ажилласан.	2021 онд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөө	Төлөвлөгөөнд тусгагдсан сургалтуудыг хийж гүйцэтгэснээр албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.	Байгууллагын 2021 онд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөөг 5 чиглэлээр 31 сургалтыг явуулахаар боловсруулан, батлуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд хамт олны дунд 4 сургалтыг зохион байгуулж явууллаа.	
	4.4	Үндэсний аудитын газрын хэмжээнд болон бүсчилсэн байдлаар хийгдэх сургалтуудад албан хаагчдыг хамруулах арга хэмжээг зохион байгуулах	Сургалт, хөгжлийн стратегийн хүрээнд бүх төвшний аудитор, шинжээчид хамрагддаг	Албан хаагчдыг бүрэн хамруулсан байх	Үндэсний аудитын газраас зохион байгуулсан арга хэмжээнд албан хаагчид хамрагдана.	Үндэсний аудитын газрын хэмжээнд болон бүсчилсэн байдлаар сургалтууд хийгдээгүй	
	4.5	Үндэсний аудитын газраас зохион байгуулсан арга зүйн болон шинэчилсэн стандартуудыг ойлгох онлайн сургалтуудад албан хаагчдыг цаг тухай бүрд хамруулах	Аудитын дээд байгууллагын олон улсын шинэчилсэн стандартууд	Төрөлжсөн аудитын шинэчилсэн олон улсын стандартыг ойлгуулах, хамрах хүрээ нэмэгдүүлэх	Зохион байгуулсан арга зүйн болон стандартыг таниулах сургалтад албан хаагчдыг хамруулсан байна.	Үндэсний аудитын газраас зохион байгуулсан арга зүйн болон шинэчилсэн стандартуудыг ойлгох онлайн сургалтуудад албан хаагчдыг цаг тухай бүрд хамруулсан	
3.9	4.6	Байгууллагын дотоод сургалтын хэрэгжилтийг тайлагнах	Өмнөх онд дотоод сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан сургалтуудыг хийж гүйцэтгэсэн	2021 онд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт	2021 онд дотоод сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан сургалтуудыг бүрэн хийж гүйцэтгэснээр албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.	Тайлант хугацаанд хамт олонд дараах сургалтуудыг зохион байгуулж явууллаа. <ul style="list-style-type: none"> <li>✓ Санхүүгийн тайлангийн аудитын талаар Үндэсний аудитын газраас ирсэн чиглэл, заавар журмаар тус байгууллагын аудиторрууд болон хувийн аудитын компанийн аудиторруудад аудитын менежер Г.Хашцэцэг, Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Д.Оюунжаргал нар,</li> <li>✓ “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам”-ыг хамт олонд танилцуулах сургалтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн</li> <li>✓ “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын сургалтыг аудитор Б.Жалбаа</li> <li>✓ “ТАБ-ын дэргэдэх Ахмадын хорооны дүрэм”, “Амадын</li> </ul>	

						сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ыг хамт олонд танилцуулах сургалтыг аудитын менежер Г.Хашцэцэг нар тус тус хийлээ.	
3.11	4.7	Үндэсний аудитын газраас боловсруулан гаргасан, жагсаалтад тусгагдсан албан хаагчдын уншиж судалсан байх хууль, дүрэм, журам, зааврыг нийтийн хүртээл болгох ажлыг удирдан зохион байгуулж, удирдлагаар хангах	Аудитын чиглэл бүрээр ангилсан жагсаалт гаргадаг.	Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны, Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай гэх мэт хуулиуд, АДБОУС-ын тухай мэдлэг, аудитын үйл ажиллагааны дүрэм, журмууд, гол гол эрх зүйн актууд	Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг дээшилж, ажлаа ур чадвартай гүйцэтгэх чадавх дээшилсэн байна.	Шинэчлэгдэн гарч буй хууль, дүрэм зааврыг хамт олонд танилцуулах ажлыг дотоод сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шинэчлэгдсэн 4 журмаар дотоод сургалтыг хийсэн.	

**ТАВ. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ЗАСАГЛАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ**

**Зорилт 5.1 Тогтвортой хөгжлийн засаглалын бодлогыг Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх стратеги зорилтын хүрээнд**

5.5	5.1	Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж баталгаажуулах	Байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2020 оноос эхлэн шинээр боловсруулж эхэлсэн	ТАБ-ын төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмыг хэрэгжүүлсэн байх	Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдаж хэрэгжсэн байна	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар батлагдсан ТАБ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 59 ажлыг гүйцэтгэхээр боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Тамгын дарга Ц.Ганболд нараар батлуулан, мөрдөж ажиллаж байна.	
-----	-----	---	---	---	---	---	--

**Зорилт 5.2 Төрийн аудитын байгууллагын дотоод засаглал, дэмжих үйлчилгээг төлөвшүүлэх стратеги зорилтын хүрээнд**

5.10	5.3	Байгууллагын хүний нөөцийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэл, мэдээллийн санг удирдах, тайлагнах, хэрэгжилтийг хангах	Хүний нөөцтэй холбоотой дүрэм журмуудыг хэрэгжүүлсэн	Хүний нөөцтэй холбоотой тушаал шийдвэрүүдэд холбогдох хууль, журмуудыг ашигласан байх, хүний нөөцийн бүртгэлийн системийг нэвтрүүлсэн байх	Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан, хүний нөөцийн бүртгэлийн систем нэвтэрч, төлөвшсөн байна	Санхүүгийн тайлангийн аудитад 1 ажилтныг гэрээгээр ажиллуулсан. Нийцлийн аудитын ахлах аудитор Ч.Бямбасүрэн УБ хот шилжиж, аудитор Г.Заяаг ахлах аудитораар, нягтлан бодогч, дотоод ажилтан Ц.Оюунсүвдыг аудитораар томилон ажиллуулахаар МУЕА-т хүсэлт уламжлан тус тус томилогдон ажиллаж байна. Нягтлан бодогч, дотоод ажилтнаар 2021 оны 2-р сарын 1-с Ц.Баасанжаргалыг томилон ажиллуулж байна. 2021 онд байгууллагад 1 орон тоо батлагдаж Г.Баасанжаргалыг томилуулахаар холбогдох материалыг хүргүүлсэн. Албан хаагчдын бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна.	
5.11	5.4	ТАТХ-д тусгасан эдийн засгийн баталгаа, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг ТАБ-ын хэмжээнд урт болон богино хугацаагаар төлөвлөж, хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах, “Нийгмийн хамгааллын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах	ТАБ-ын Нийгмийн хамгааллын хөтөлбөрийн дагуу арга хэмжээ зохион байгуулсан	Хөтөлбөрт тусгагдсан шалгуур үзүүлэлтийг хангасан байх	Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан, хэрэгжилтийн үр дүнг үнэлж тайлагнасан байна	ТАТХ-д тусгасан эдийн засгийн баталгаа, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг байгууллагын хэмжээнд урт болон богино хугацаагаар төлөвлөж, хэрэгжүүлэх ажлыг УАГ-т уламжлан “Нийгмийн хамгааллын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
5.12	5.5	ТБАНТХ, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, ТАБ-ын төрийн болон албаны нууц хамгаалах дотоод журмын хэрэгжилтийг хангах.	Байгууллагын нийт ажилтнуудаар нууцын баталгаа гаргуулж авсан, шинэ ажилтнуудад сургалт зохион байгуулсан	Хууль тогтоомжид заасны дагуу төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журмыг мөрдөж ажилласан байх	ТАБ-ын Төрийн болон албаны нууц хамгаалалт, бүртгэл хөтлөлт, архивын хадгалалт хамгаалалт сайжирсан байна	Хууль тогтоомжид заасны дагуу төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журмыг мөрдөн ажиллаж байна.	
5.20	5.6	Монгол Улсын Ерөнхий аудитороос өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх	Монгол Улсын Ерөнхий аудиторын өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр хэрэгжүүлэн ажилладаг	Монгол Улсын Ерөнхий аудиторын өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр хэрэгжүүлсэн байх	Монгол Улсын Ерөнхий аудиторын өгсөн үүрэг чиглэл тухай бүр хангагдсан байна	Монгол Улсын Ерөнхий аудитороос өгсөн үүрэг чиглэлийг тухай бүрт нь хэрэгжүүлэн ажиллаж тайлагнаж байна.  МУЕА-ын 2020 онд баталсан “А” тугаалаас байнга хэрэгжих тушаалуудын хэрэгжилтийг ханган ажиллаж байна	

5.22	5.7	Байгууллагад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох шаардлагад нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтийг ханган тайлагнах	ҮАГ-ын хэмжээнд худалдан авах ажиллагаа 7 удаа зохион байгуулсан	Байгууллагын зохион байгуулалтын нэгжээс ирүүлсэн ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангасан байх	Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авах үйл ажиллагааг холбогдох хуулийн хэрэгжилтийг ханган зохион байгуулж, тайлан мэдээ гарсан байна	Тайлант хугацаанд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа гараагүй болно	
5.23	5.8	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан	Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд тайлагнасан байх	Шилэн дансны тухай хуулийг бүрэн дүүрэн хэрэгжүүлж ажилласан байна	СТА-аар байгууллагуудын шилэн дансны хэрэгжилтэд аудит хийж, аудитын дүнг шилэн дансны программд байршуулсан. Шилэн дансны мэдээлэл хангалтгүй байгууллагуудад зөвлөмж өгсөн болно.  “Шилэн дансны тухай” хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангах ажлын хүрээнд байгууллагын төсвийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, зарцуулалт болон төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг сар бүр хуулийн хугацаанд <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> сайтад байршуулан мэдээлж, улирал бүр холбогдох дээд шатны байгууллагад илгээж, мэдээ тайлангийн хоцрогдолгүй ажиллаа.	
5.24	5.9	Байгууллагын албан хэргийг хөтлөн явуулах, архивын үйл ажиллагааг хуулийн хүрээнд эрхлэх, цахим баримт бичгийн бүртгэл хөтлөх, кодлох, мэдээлэх, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг тайлагнах.	Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар, дүрэм, журмын дагуу тухай бүрд нь бүртгэл хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан	Албан хэрэг хөтлөлт хууль, журмын дагуу хийгдсэн эсэх, бүртгэл болон цахим санг бүрэн хөтөлсөн байх	Зохион байгуулалтын нэгжүүдийн албан хэрэг хөтлөлт, цахим санг боловсронгуй болгох, баримт бичигтэй ажиллах ажиллагаанд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангасан байна	Байгууллагын албан хэргийг хөтлөн явуулах, архивын үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж, ББНШ-х комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, жилийн ажлын төлөвлөгөө гарган батлуулан ажиллаж байна.  2021 оны эхний хагас жилд дарга бөгөөд тэргүүлэх аудиторын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой А тушаал 102, боловсон хүчинтэй холбоотой Б тушаал 11 гарсан байна. Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр гаргасан тушаалаас аудитын тайлан баталгаажуулах 2 , акт, албан шаардлага баталгаажуулах 89, тушаал зохион	

						байгуулалтын чиглэлээр 8, хөрөнгө зарцуулахтай холбоотой 2 тушаал байна. Мөн байгууллагад ирсэн бичиг 139, явуулсан бичиг 551 бүртгэгдэж, 14 байгууллага, 1 иргэнээс ирсэн өргөдөл хүсэлтийг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэж, хариуг хүргүүлэн ажиллаа.	
<b>Зургаа. “Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги”-ийн хүрээнд</b>							
1.3	6.1	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын 2.4-т заасан тогтвортой хөгжлийн засаглалын бодлогыг байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын 2.4-т заасан тогтвортой хөгжлийн засаглалын бодлогыг байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна	
	6.2	Аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг дээшлүүлж, үйл ажиллагааны тайлан гаргах	Аудитын зөвлөмжийн мөрөөр хийсэн ажлын тайланг авч, түүвэрчлэн хэрэгжилтийг шалгадаг.	Аудитаар өгөгдсөн зөвлөмж бүрийн хэрэгжилтийг шалгах	Аудитаар өгөгдсөн зөвлөмж бүрийн хэрэгжилт үр дүнтэй болно.	Аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг дээшлүүлж, зөвлөмжийн биелэлтийг 14 хоног бүрээр гарган хамт олны шуурхайгаар хэлэлцэж байна. Тайлант хугацаанд хийгдсэн 8395.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 329 заалт бүхий зөвлөмж хүргүүлж, 594.2 сая төгрөгийн 172 зөвлөмжийн биелэлтийг хангуулж, 7604.3 сая төгрөгийн 79 заалт бүхий зөвлөмжийн хэрэгжих хугацаа болоогүй бөгөөд 196.5 сая төгрөгийн 78 заалт бүхий зөвлөмж заасан хугацаанд хэрэгжээгүй байна.	
1.4	6.3	Аудитын чанарын хяналтын тогтолцоог төлөвшүүлж, эрсдэлд суурилсан төрийн аудитыг хэрэгжүүлэх	Аудитын чанарын хяналтыг хэрэгжүүлж, эрсдэлд суурилсан аудитыг хийж байна.	МУЕА-ын 2018 оны А/221 дүгээр тушаалаар батлагдсан “Аудитын чанарын хяналтын журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	Аудитын чанарын хяналтын тогтолцоог төлөвшүүлж, эрсдэлд суурилсан төрийн аудитыг хэрэгжүүлсэн байна.	Аудитын чанарын хяналтын тогтолцоог төлөвшүүлж, эрсдэлд суурилсан төрийн аудитыг хэрэгжүүлэх ажлыг зорилт болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.	
	6.4	Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайланд хийх аудитад хөндлөнгийн хараат бус	МУЕА-ын 2017.10.26-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон	МУЕА-ын 2020.10.23-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн	Төрийн аудитын байгууллагатай гэрээгээр санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэж байгаа хувийн аудитын хуулийн этгээдийн	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайланд хийх аудитад хөндлөнгийн хараат бус аудитын хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн өмчит 2	



	аудитын хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхийг сайжруулах	шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам"-ыг мөрдөн хэрэгжүүлж ажилласан.	этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам"-ыг мөрдөн хэрэгжүүлж ажиллах	аудиторуудыг оролцуулсан сургалтыг жил бүр гүйцэтгэж, санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг бүрэн нэвтрүүлсэн байна.	компаний санхүүгийн тайланг хараат бус аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан. 2021 оны СТА-аар 6 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан баталгаажуулах ажлыг хуваарилаад байна.	
	<b>Нийт оноо</b>					

ДҮГНЭСЭН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
ТАМГЫН ДАРГА

ҮНЭЛГЭЭТЭЙ ТАНИЛЦАЖ  
ЗӨВШӨӨРСӨН:  
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Нийт оноо

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ГАНБОЛД

Д.БАТ УНДРАА